

Гүйцэтгэлийн аудитын хураангуй тайлан

Огноо: 2020.12.07

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	ОРА-2020/04-ГА	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Аймгийн ЗДТГ, БСУГ, ЕБС-ууд, МХГ
Аудитын нэр:	<i>“Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”</i>		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Гүйцэтгэлийн аудитын алба	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Ахлах аудитор В.Жавзмаа, Аудитор Б.Бямбатогтох

Хоёр. Аудитын үр дүн:

2.1 Аудитын зорилго, хамарсан хүрээ:

“Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”д улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

- Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:
- Ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх;
 - Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт хангагдаж байгаа эсэх;

Аудитыг аймгийн ЗДТГ, Боловсролын газар, МХГ, төрийн болон хувийн өмчийн ЕБС-уудын 2016-2019 оны үйл ажиллагааг /сүүлийн 3 хичээлийн жил/ хамруулан гүйцэтгэлээ.

2.2 Аудитын дүн:

2.2.1 Гол асуулт / аудитын дэд зорилт 1:

Ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх.

Хариулт 1:

Мөрдөгдөж буй хууль, дүрэм журам, норм нормативын хэрэгцээ шаардлагыг үнэн зөв тодорхойлж, харилцан уялдаатай байхаар боловсруулах шаардлагатай байна.

Хуулийн уялдаагүй байдлаас шалтгаалан томоохон хотуудад хамран сургах тойргийн дагуу бус төвлөрсөн хэсэгт анги дүүргэлт ачаалал ихсэн, сургалтын чанар хүртээмж буурч, төсөвт зардал баталдаггүйгээс холбогдох журам, дүрмийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүссээр байна.

БСШУЯ-аас захиргааны хэм хэмжээний актуудад холбогдох талуудын саналыг тусгадаг эсэх нь тодорхойгүй бөгөөд орон нутгийн боловсролын байгууллагуудаас авсан саналыг тусгадаггүй байна.

Мөрдөх эрх зүйн баримт бичгийг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж шинэчлэх шаардлага үүссэн байна. Төрөөс ерөнхий боловсрол олгохтой холбогдуулан Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд заасан дүрэм, журам, норм норматив, холбогдох хөтөлбөрийг тус тус боловсруулж баталж, мөрдүүлэхээр зааснаас дараах дүрэм, журам, норм нормативыг батлаагүй байна.

Хамран сургалтын тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд анхаарахаар болсон байна. Аймгийн ИТХ-аас баталсан төрийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг тооцсон боловч хяналт хэрэгжүүлээгүй байна. Аймгийн БСУГ жил бүр биелэлтийг гаргаж, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2020 онд аймгийн ИТХ-д хүргүүлжээ. Төлөвлөгөөний явц байдалд хяналт хэрэгжүүлээгүй бөгөөд 2020 оны эхний хагас жилийн байдлаар 90.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нэг ангид ногдох хүүхдийн тоо байршил, хэв шинж, сургалтын чанараас шалтгаалан харилцан адилгүй байх ба төрийн өмчийн томоохон сургуулиудад нормоос 5-16 хүүхдээр хэтэрсэн байна. Төрийн өмчийн 14, 4, 5, 15, 13, 1, 8 дугаар сургуулиудад 38-51 суралцагч суралцаж байгаа нь “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим ажилтны цалин хөлсийг тооцож олгох журам”-ын 4-т “анги дүүргэлтийг бага ангид 30-35” гэж зааснаас 5-16 суралцагчаар хэтэрчээ. Төрийн бус өмчийн сургуулиудын анги дүүргэлт дунджаар 18-20, төрийн өмчийн сургуулиуд 32-35 суралцагчтай байна. Зарим төрийн өмчийн сургуулийн анги дүүргэлт тогтоосон нормоос бага байгаа нь оновчтой төлөвлөлт, зохион байгуулалт шаардлагатайг илтгэж байна.

2016-2020 онд ашиглалтад орсон болон одоо баригдаж буй сургуулийн хүчин чадлыг оновчтой тодорхойлохгүйгээр төлөвлөжээ.

Сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулах шаардлага хангаагүй байранд 3 сургууль үйл ажиллагаа явуулж байна. Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм БНБД II-66-88-ын 2.6-д хүчин чадлын дээд хэмжээг ерөнхий боловсролын сургуульд 33, ерөнхий боловсролын сургуулийн цогцолборт 22+22 ангитай ангитай байхаар заасан боловч Орхон аймгийн хэмжээнд хамгийн ихдээ 75, хамгийн бага нь 19 ангитай үйл ажиллагаа явуулж байна.

Орхон аймгийн төрийн болон төрийн бус өмчийн сургуулиуд өөрийн эзэмшлийн 28 барилга, байгууламжтай бөгөөд барилгын насжилтыг авч үзвэл 40-өөс дээш жилийн насжилттай барилга 7 байна. Төрийн бус өмчийн 2, төрийн өмчийн 1 сургууль түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг байна.

Аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын барилга байгууламжийн нэгдсэн мэдээллийн сан үүсгээгүй, судалгаа байдаггүй байна. Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн хичээлийн 1-р байр 1980 онд ашиглалтад орсон бөгөөд 2010-2019 онд аймгийн МХГ-ын болон ОБГ-ын улсын байцаагчдын дүгнэлт 7 удаа гарч, сүүлийн жилүүдэд 698.7 сая төгрөгийн их засвар хийгдсэн ч үр дүнгүй хөрөнгө оруулалт болжээ. Одоогийн байдлаар дээвэр, гадна фасадын хэсгээр ус гоожиж, мөөгөнцөртсөн, мэрэгч шавж үүрлэсэн хэвээр байна.

Төрийн өмчийн 16, төрийн бус өмчийн 8 сургуулиудад химийн 13, физикийн 16, биологийн 12, гадаад хэлний 20 кабинеттай байна. Харин төрийн өмчийн 3, төрийн бус өмчийн 5 сургууль нь кабинет, лабораторигүй байна. Ихэнх сургуулиудын кабинет, лабораториуд нь түүнд тавигдах шаардлагыг бүрэн хангаагүй, бүрэн бус тоног төхөөрөмжтэй, хичээлд хэрэглэх урвалж бодис, сургалтын хэрэглэгдэхүүнээр бүрэн хангагдаагүй байна.

Аудитын явцад сургуулиудын үйл ажиллагааг газар дээр нь шалгахад гадаад болон дотоод орчны зарим шаардлагыг хангахгүй байна. Үүнд гадаад орчин нийт сургуулиудын эзэмшил газар нь иж бүрэн гэрэлтүүлэггүй, зам талбайн зогсоолын тэмдэг тэмдэглэгээгүй, 20 дугаар сургуулиас бусад сургуулиудын барилга хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаагүй, тэдний шаардлагад бүрэн нийцүүлээгүй, нийт сургуулиудын 80 хувийнх нь биеийн тамирын болон сургалт-туршилтын талбай шаардлага хангадаггүй, ихэнх сургуулиуд хог, хаягдал түр хадгалах цэг стандартад заасан шаардлага хангаагүй, сургуулиудын хяналтын камер гадна орчныг бүрэн хянах боломжгүй, дүрс бичлэгийг 1 сар хадгалах боломжгүй байна. Дотоод орчин барилга байгууламжийн дотор цахилгаан холболт болон гэрэлтүүлэг, хүчний тоноглолд урсгал засвар, шинэчлэлтийг тогтоосон хугацаанд тогтмол хийх урсгал засварын зардал хангалттай батлаагүйгээс эвдэрсэн тухайд засварладаг, анги танхимын хүрэлцээгүй байдлаас шалтгаалан барилгын төлөвлөлтийн норм, дүрмийн дагуу баригдсан өрөө, тасалгааны зориулалтыг төрийн өмчийн томоохон сургуулиуд өөрчилсөн гэх мэт.

Шинээр ашиглалтад орох ЕБС-уудын хүрэлцээг бүрэн хангах, стандартад нийцсэн сургалтын орчныг бий болгоход яам бодлого, төлөвлөгөөтэй шийдвэрлэх хэрэгтэй байна.

Яамны хөрөнгө оруулалтаар сургуулиудад нийлүүлэх техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанар, бүрэн байдалд анхаарч, ашиглах боломж нөхцөлөөр хангах шаардлагатай байна.

2016-2019 оны байдлаар дуу хөгжим, технологи, физик, орос хэлний багш жил бүр дутагдалтай байсан ба цаашдаа физик, хими, дуу хөгжмийн багшийн хүрэлцээ хангалтгүй болохоор байна гэж холбогдох мэргэжилтнүүд тайлбарлаж байна.

Хотын төвийн сургуулиудад багшийн хүрэлцээ хангалттай бөгөөд сонгон шалгаруулалтаар эсвэл дадлага туршлагатай багшид санал тавих байдлаар шийдвэрлэдэг байна. Харин хотын захын сургуулиудад хичээлийн төлөвлөгөө, хөтөлбөртэй уялдуулан хосолсон мэргэжлийн багш ажиллуулахад хүндрэлтэй бөгөөд тухайлсан судлагдахуунаар мэргэшсэн байх боловч ажлын байранд тавигдах шаардлага хангахгүй байх, шинээр авч дадлагажуулж, туршлагажсан багшийг тогтвортой ажиллуулах бодлого байхгүйгээс өөр сургуульд шилжих зэрэг хүндрэл бэрхшээл үүсдэг байна. Мөн “иргэний ёс зүйн боловсрол” хичээлийг шинээр заахаар төлөвлөгөө, хөтөлбөрт тусгасан хэдий ч тухайн судлагдахуун заах багш бэлтгэгдээгүй, нийгмийн ухааны багш заахаар тусгасан байна.

БСШУЯаманд мэргэжлийн багшийн судалгаа боловсролын салбарын мэдээллийн системд нэгтгэгддэг хэдий ч багш бэлтгэх их дээд сургуультай хэрхэн уялддаг нь тодорхойгүй байна. Харин аймгийн БСУГ нь шинээр төгссөн болон ажилгүй байгаа багшийн судалгааг хичээлийн судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүдээр бүртгүүлж, нэгтгэдэг байна.

Салбарын яам боловсролын салбарын мэдээллийн системд нэгтгэгддэг багш нарын судалгаанд үндэслэн мэргэжлийн их дээд сургуулийн төлөвлөлттэй уялдуулж, бодлогоор мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээнд анхаарах, тогтвор суурьшилтай ажиллуулж ур чадварыг бодитой үнэлэх бодлого шаардлагатай байна.

Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, холбогдох журмыг хэлэлцүүлж, хянагдаж байгаа бөгөөд үр дүнтэй ажил зохион байгуулж эхлээгүй байна.

Тухайлсан иргэнд зориулсан туршлага, шаардлагаас болж 3 ажлын байранд тэгш өрсөлдөх боломжийг хязгаарласан байна. БСШУС, НХХС-ийн болон Сангийн сайдын хамтарсан 307/91/237 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэг, ЕБС-ийн багш, зарим албан

тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам"-аар нэг багш долоо хоногт 19 цагийн хичээл заах ёстой байтал, тухайн сургуулийн ангийн тоо, сонгон суралцах хичээл зэргээс хамаарч 18-21 цагийн хичээл заахаар, төлөвлөгөө хөтөлбөр зохиогдож байна. Багшийн тухайд ахлах ангийн мэргэжлийн болон сонгон судлах хичээлийн бүлэг дүүргэлтийг 25-30 гэж заасан нь цөөн хүүхэдтэй сургуульд бүлэг дүүргэлт хүрэхгүйгээс суралцагчийн сонгон судлах эрхийг хязгаарлаж, олонхыг дагасан сонголтоор хичээллэсэн байна.

Багшаас бусад ажилтны тухайд орон тооны жишиг нормативд суралцагчийн тоог сургуулийн барилга байгууламжийн суурилагдсан хүчин чадлаар тооцохоор тусгасан нь бодит байдлаас зөрүүтэй үзүүлэлт болжээ. Аймгийн хэмжээнд бодит хүчин чадлаас хоёр дахин хэтэрсэн 5, 160-320 хүүхдээр хэтэрсэн 4 сургууль байна. Энэ нь төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг хянах арга хэдий ч, сургалтын орчны ачаалал нэмэгдэж, ажил үүргийн уялдаа алдагдахад хүргэж байна.

Аймгийн хэмжээнд 2,000-аас дээш суралцагчтай 4 сургууль байгаа бөгөөд, сүүлийн жилүүдэд байгууллагын үйл ажиллагааны тайлан, судалгааг Цагдаагийн газар, ОБГ, ЭМГ, ГБХЗХГ, Статистикийн хэлтэс, БСУГ, аймгийн ЗДТГ-ын хэлтсүүд шаарддаг байна. Энэ нь сургалтын менежерүүд арга зүйгээр хангах, хичээлийн чанарт тавих хяналт цаг завьг хязгаарлахад хүргэдэг байна. Боловсролын салбарын мэдээллийн системд тайлан, мэдээлэл оруулахад цаг хугацаа их шаарддаг, интернэтийн орчны хязгаарлагдмал байдлаас ажлын ачаалал нэмэгддэг байна. Иймд бодит хүүхдийн тоо болон сургуулийн орчны нөхцөлд үндэслэн судалж, захиргааны удирдлагын тоог тогтоохоор байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс шалтгаалан 2013 оноос хүүхэд төлөвшлийн ажилтан ажиллуулж, цалин хөлсийг орон нутгийн төсвөөс олгож байсан ба 2015 оноос сургуулийн төсвөөс цалинждаг болжээ. Тухайн ажилтнаар багш нар ажилладаг бөгөөд үүнийг бодлогоор дэмжин, сэтгэл зүйчийг ажиллуулахыг сургуулиуд чухалчилж байлаа.

Үдийн цайны хөтөлбөрийг ашгийн төлөө компаниар гүйцэтгүүлж буй нь нэг талаас дотоодын аж ахуйн нэгжийг дэмжиж буй нөгөө талаас чанар байдалд хяналт хэрэгжүүлж, хариуцлага хүлээлгэх боломжгүй байдал үүсгэдэг байна. Мөн тухайн компанийн ажилтнууд байнга солигдох нь эрүүл ахуй болон хоол, хүнсний чанарт нөлөөлдөг байна. Иймд үдийн цай хөтөлбөрийг аж ахуйн нэгж, эсвэл тухайн сургууль хэрэгжүүлснээр төсөвт үүсэх ачаалал, улсын төсөвт төвлөрүүлэх татвар, хүүхдэд хүргэж буй бодит хүнсний тооцоо судалгааг харьцуулж тооцоолон, үр өгөөжтэй байх боломжит хувилбарыг тогтоох нь үр дүнтэй байна.

Салбарын яам сургуулиудыг барилга байгууламжийн суурилагдсан хүчин чадлын дагуу ажиллуулах асуудлыг шийдвэрлэх, эсхүл сургуулиудын хүний нөөцийн бодлогыг байршил, хэв шинж, орчин нөхцөл байдал, ачаалал зэргийг харгалзан бодитой тогтоох шаардлагатай болжээ.

Боловсролын салбарын мэдээллийн системд улсын хэмжээний бүх суралцагч, багш, ажилтны болон сургуультай холбоотой бүх мэдээллүүд нэгтгэгддэг байна. Салбарын яам энэхүү мэдээлэлдээ тулгуурлан багшийн эрэлт, хэрэгцээний судалгаа хийж, санал дэвшүүлсэн эсэх нь тодорхойгүй байна.

Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тогтоохдоо сургуулийн хүчин чадал, багтаамжийг харгалзах итгэлцүүргүйгээс төсвийн хуваарилалт харилцан адилгүй хуваарилах нөхцөл үүсдэг байна.

Мөн ЕБС эзэмшүүлэхэд 1 суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг батлахдаа бусад хувьсах зардлыг аймагт 13,900 төгрөгөөр, 10 нэр төрлийн зардлыг багтааж баталсан хэдий ч, уг зардлыг хэрхэн хуваарилах талаар зохицуулалт, аргачлал байхгүй байна. Дотуур байрны хүүхдийн тоог бодит гүйцэтгэл, шинэ элсэлт, 12-р ангийн төгсөлт зэргийг судалж, үнэн зөв төлөвлөх шаардлагатай байна.

Ном, сурах бичигт шаардлагатай хөрөнгийг бодитой тооцож төлөвлөөгүй, гүнзгий ангийн сургалтын төлбөрийн орлогоос төлөвлөдөг байна.

Шаардлагатай гарын авлага, сургалтын үзүүлэн болон бусад хэрэглэгдэхүүний төсвийг сургуулиуд төлөвлөдөг хэдий ч төсөв батлагдахад буурдаг байна.

Засгийн газар Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-т “сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно” гэж заасны дагуу итгэлцүүр тогтоогоогүйгээс хувьсах зардлын дундаж нормативыг мөрдөөгүй байна. Иймд салбарын яам шинэчлэн тогтоох талаар асуудлыг Засгийн газарт уламжилж, шийдвэрлүүлж байх шаардлагатай байна. 2016 – 2019 онд тухайн хичээлийн жилийн албан ёсны статистикийн мэдээлэл дэх хүүхдийн тоогоор тооцохгүйгээр 376.5 сая төгрөгийн хувьсах зардлын санхүүжилтийг илүү олгосон байна.

Төрийн бус өмчийн ЕБС-д 2019 онд 109.0 сая төгрөгийг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дах заалт, Боловсролын тухай хуулийн Засгийн газрын 242 дугаар тогтоолын 6-р хавсралтын 4.4, 4.5 дах заалтуудыг тус тус зөрчиж байх тул төлбөрийн акт тогтоов.

Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хуульд заасны дагуу төрийн өмчийн ЕБС-ийн жил бүрийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж, нийт 13,214.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлж тухай бүр холбогдох арга хэмжээг авч ажилласан. Алдаа, зөрчлийн дүн буурсан хэдий ч нийтлэг алдаа зөрчил буурахгүй, давтагдсаар байгаад аймгийн Засаг дарга, СТСХ, БСУГ-ын зүгээс батлагдсан төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэхтэй холбоотой дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Аймгийн БСУГ нь төрийн бус өмчийн ЕБС-уудад төсвийн хуваарийг баталдаг ч хяналт хэрэгжүүлээгүйгээс хувьсах зардлын болон үдийн цай хөтөлбөрийн санхүүжилт илүү олгосон байх тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

Төрийн өмчийн ЕБС-ийн үдийн цай хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийг 2016-2018 онд тухайн сургуулиуд, 2019 оноос БСУГ-т тендер шалгаруулалтыг ТБОНӨХБАҮХАТХууль, холбогдох журамд нийцүүлэн зохион байгуулжээ. Үдийн цай хөтөлбөрийн сонгон шалгаруулалт, зарцуулалтыг жил бүр санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан ба 2016-2019 онуудад 438.9 сая төгрөгийн шаардлага хүргүүлжээ. Албан шаардлагын биелэлт 2019 онд бүрэн хэрэгжсэн байна.

Төрийн бус өмчийн 4 ЕБС-д 2016-2019 онд 182.9 сая төгрөгийн үдийн цай хөтөлбөрийн зардлын санхүүжилт олгохдоо тухайн хичээлийн жилийн хүүхдийн статистик тоонд үндэслээгүй, хүүхэд өдрөөр хянахгүйгээр 17.1 сая төгрөгийн зардал илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2, 41.2.7 дах заалт, Засгийн газрын 450 дугаар тогтоолын 4-т “нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх” гэж заасныг зөрчиж байх тул төлбөрийн акт тогтоов.

2.2.2 Гол асуулт / аудитын дэд зорилт 2:

Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт хангагдаж байгаа эсэх.

Хариулт 2:

Багш эзэмшүүлбэл зохих боловсрол, ур чадварыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу бүрэн эзэмшүүлсэн гэж үнэлсэн байх боловч гүйцэтгэлийн үнэлгээ бодитой бус байна.

Төгсөгчдөөс улсын шалгалт авсан тухай тайланг БСУГ жил бүр салбарын яаманд хүргүүлдэг бөгөөд, тухайн тайланд зохион байгуулалт, шалгалтын материал боловсруулалт, гүйцэтгэл, цаашид хийх ажлын чиглэл, анхаарах асуудал /улс, орон нутгийн хэмжээнд/, нэгдсэн дүгнэлт гэсэн агуулгаар бичдэг байна.

Улсын хэмжээнд зохион байгуулж буй элсэлтийн ерөнхий шалгалтын сорил, тест нь стандартаар эзэмших ур чадвараас давсан агуулгаар бэлтгэгддэг, үүгээр сургуулиудын сурлагын чанар, үр дүнг үнэлэх нь зохимжтой бус гэж үзсэн тул тухайн шалгалтын дүнг аудитад дурдаагүй болно. Нэг талаас эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ ур чадвар, боловсролыг хоцроохгүй, илүү түвшинд сургах гэсэн хүслээр тухайн шалгалтад бэлтгэх багш нартай хамтран ажилладаг нь нийтлэг байх тул элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээг бодитой үнэлгээ гэж үзээгүй болно. Эндээс нэгтгэн дүгнэвэл багш эзэмшүүлбэл зохих ур чадварыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу бүрэн олгосон гэж үнэлсэн байх боловч гүйцэтгэлийн хувь 13-20 хувиар зөрүүтэй байна.

Аймгийн боловсролын газар сурлагын чанарын бууралтад нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа хийж, нэгдсэн бодлого, арга зүйгээр дэмжиж, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Сургалтын чанарт нөлөөлөх нөлөөллийн судалгааг чанарын үнэлгээний шалгалт авахад хийгддэг ба Боловсролын үнэлгээний төв тайландаа тусгаж, салбарын яаманд хүргүүлдэг байна.

Аймгийн хэмжээнд сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа хийдэггүй байна. Харин аудитын явцад хийсэн уулзалт ярилцлага, дотоод хяналтын нэгжийн шалгалтын дүнгээрх тайлан мэдээнд тусгасан хүчин зүйлсийг дурдвал:

Сургуулиудын байршил – хотын төвийн сургуулийн хүүхдийн тоо хүчин чадлаас хоёр дахин их байдаг, захын сургууль бүрэн хүчин чадлаараа ажилладаг тул сургалтын ачаалал харилцан адилгүй байдаг.

Өмчийн хэлбэр – Төрийн бус өмчийн сургууль ачаалал багатай, сургалтын төлбөр төлдөг тул багш нараас хариуцлага, үр дүн шаарддаг.

Багшийн ур чадвар – Хотын төвийн сургуулиудын сургалтын орчин сайн тул захын сургуульд ур чадвартай багшийг тогтвор суурьшилтай ажиллуулах дэмжлэг байхгүйгээс шилжилт хөдөлгөөн байнга хийгддэг.

Сургалтын орчин – Хотын төвийн томоохон сургуулиудын сургалтын орчин сайн бүрдсэн, захын сургуулиудын сургалтын орчин бүрэн бүрдээгүй, дутагдалтай.

Хөтөлбөрийн олон удаагийн өөрчлөлт – Хөтөлбөрийг оновчтой судалгаа, шинжилгээгүйгээр баталснаар сүүлийн 10-аад жилд тогтвортой хөтөлбөр мөрдөөгүй, ном сурах бичиг дахин дахин хэвлэгдэж байсан.

Эцэг эхийн оролцоо – Хотын төвийн сургуулиудын эцэг эхийн оролцоо сайн байдаг бол захын сургуулиудад хангалтгүй байдаг байна. Амьдралын боломж, нийгмийн байдал, гэр бүлийн харилцаа зэргээс шалтгаалдаг байна.

Аймгийн БСУГ болон ЕБС-уудад БСШУЯ-аас 2016-2019 онд хяналт хэрэгжүүлээгүй байна. Харин 2020 онд БСУГ-ын удирдлага, санхүүгийн 2018, 2019 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийсэн бөгөөд үр нөлөөтэй эсэх нь тодорхойгүй байна.

Аймгийн БСУГ нь хичээлийн жилийн эхэнд зөвлөн туслах, гарааны үнэлгээ тогтоох ажлыг удирдамжийн дагуу холбогдох мэргэжилтнүүд судлагдахууны дагуу, сургуулийн үйл

ажиллагааг үнэлдэг байна. Удирдамжийн дагуу үнэлгээг нэгтгэж, салбарын удирдлагын хуралдаанд танилцуулж, зөвлөмж өгдөг бол ахиц, гүйцэтгэлийг хичээлийн жилийн эцэст хавар үнэлдэг байна. Зөвлөн туслах, гарааны үнэлгээ тогтоох ажлын мөрөөр хийсэн дүгнэлт зөвлөмж боловсруулдаг боловч тайланг сургууль бүрд хүргүүлээгүй бөгөөд ахиц, гүйцэтгэлийг нэгтгэж дүгнэн, хэлэлцсэн тайлан байхгүй байгаа нь дотоод хяналтын үр нөлөөг бууруулж байна.

МХГ-ын 2020 оны 03/403 дугаартай албан бичгээр Орхон аймгийн ЕБС-уудад 2016 онд 16, 2017 онд 13, 2018 онд 27, 2019 онд 19 сургуулиудын хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээний эрсдэлийн үнэлгээг ирүүлсэн. Нийт ЕБС-уудаас 2016 онд 64.0 хувь, 2017 онд 52.0 хувь, 2018 онд 76.0 хувь, 2019 онд 76.0 хувийг хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээнд хамруулсан байх ба 2018 онд 8, 2019 онд 6 сургууль давхардсан байдлаар хамрагдсан байна. Аймгийн МХГ-аас ерөнхий боловсролын сургуулиудад холбогдох хууль тогтоомж, “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS 6782:2019” уг стандартыг хэрэгжилтэд хийсэн шалгалтаар илэрсэн дараах нийтлэг зөрчлүүд бүрэн арилаагүй, давтагдсаар байна.

Эцэг эхийн оролцоо хотын төвийн болон захын сургуулиудад харилцан адилгүй байдаг ба энэ нь амьдралын боломж, нийгмийн байдал, гэр бүлийн харилцаа, ухамсар зэргээс шалтгаалдаг байна. Аудитын явцад сургуулиудын удирдлагатай уулзалт, ярилцлага хийх явцад “эцэг эх нь олдохгүй, уулзахгүй байх тохиолдолд харьяа багт хандаж, уулздаг ч тохиолдол байдаг, зарим багийн нийгмийн ажилтан иргэдээ хаана байгааг ч мэддэггүй, тэднийг хариуцлагатай ажиллуулах цаг болсон” гэж байсан нь анхаарч үзэхээр асуудал байна. Сумдын засаг дарга нар анхан шатны нэгж болох багийн дарга, нийгмийн ажилтнуудын хариуцлагыг сайжруулж, судалгаа, мэдээллийг тухай бүр шинэчлүүлэх, түүнд хяналт хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эцэг эх, олон нийтийн зүгээс сургуулиудын зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцож, санал асуулгаар тухайн сургуулийг үнэлдэг байна. Энэхүү санал асуулга үр дүнтэй эсэх нь тодорхойгүй бөгөөд аймгийн МХГ үнэлэхдээ сургуулийн зөвлөл хангалтгүй ажилладаг, аймаг орон нутгийн удирдах ажилтнууд зөвлөлийн даргаар ажилладаг бөгөөд хурал үр дүнтэй болдоггүй гэж дүгнэсэн байна. Иймээс сургуулийн зөвлөлийг үр дүнтэй ажиллуулах, үйл ажиллагааны хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2.3 Аудитын гол дүгнэлт

**ТӨРӨӨС ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОХ ЭРХ ЗҮЙН БОЛОН СУРГАЛТЫН
ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ, СУРГАЛТЫН ЧАНАРТ АНХААРАХ
ШААРДЛАГАТАЙ БОЛЖЭЭ.**

2.4 Аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс			
		Тоо	Дүн	Зөвлөмж	Төлбөрийн акт	Албан шаардлага	Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
А	1	2	3	4	5	6	7
1	Аймгийн Засаг дарга	1		1			
2	Аймгийн ИТХ	1		1			
3	Аймгийн ЗДТГ-ын СТСХэлтэс	1		1			
4	БСУГ	6	519.8	3	2	1	
	ДҮН	9	519.8	6	2	1	